



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

“Дэлгэрхангай секюритиз” ХХК-ийн  
брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг сунгах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2, 10.1.5 дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дэлгэрхангай секюритиз” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2012 оны 8 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Дэлгэрхангай секюритиз” ХХК /М.Бат-Оргил/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН